ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/352/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Гэрээт аудитор: О.Наранбат
Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

Агуулга 1
1.Аудитын санал дүгнэлт 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан 12
3.1 Ерөнхий зүйл 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хянал 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 14
3.4 Материаллаг байдал 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 17
3.8 Аудитын гол асуудал 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 18
4. Аудитын илрүүлэлт 19
4.1 Залруулсан алдаа 19
4.2 Төлбөрийн акт 19
4.3 Албан шаардлага 19
4.4 Зөвлөмж 20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 21

Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн нэгдсэн улс
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ДАРГА Я.ЭРДЭНЭСАЙХАН ТАНАА

2022.02.24 № 07/308
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
90191203 96

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**1,388,634,616.00**	**973,162,202.13**
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	600.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	600.00	-
31110	Төгрөг	600.00	-
33	АВЛАГА	3,997.00	289,031,493.13
335	Бусад авлага	3,997.00	66,433,489.46
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,997.00	3,997.00
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,388,630,019.00	676,930,709.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	690,873,000.00	-
354	Хангамжийн материал	697,757,019.00	676,930,709.00
35410	Бичиг хэргийн материал	8,082,150.00	9,101,300.00
35420	Аж ахуйн материал	16,062,300.00	26,966,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,499,000.00	6,587,000.00
35440	Түлш, шатах тослох материал	443,300.00	1,506,700.00
35450	Барилгын засварын материал	270,000.00	270,000.00
35470	Бусад хангамжийн материал	666,400,269.00	632,498,809.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**525,457,352.15**	**453,339,417.44**
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	525,457,352.15	453,339,417.44
392	Биет хөрөнгө	311,537,352.32	297,959,417.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	74,770,370.00	74,770,370.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,686,488.50)	(35,680,169.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,600,000.00	172,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(43,149,999.96)	(71,916,666.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	162,987,246.56	223,883,146.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,385,372.89)	(97,937,254.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	97,586,539.00	97,586,539.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(61,062,441.89)	(68,894,046.75)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,950,000.00	4,950,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,072,500.00)	(1,402,500.00)
393	Биет бус хөрөнгө	213,919,999.83	155,379,999.75
39301	Програм хангамж	243,200,000.00	243,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(117,580,000.17)	(176,120,000.25)
39303	Бусад биет бус хөрөнгө	88,300,000.00	88,300,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**1,914,091,968.15**	**1,426,501,619.57**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**83,836,050.00**	**12,310,556.36**
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	83,836,050.00	12,310,556.36
413	Өглөг	83,836,050.00	12,310,556.36
4136	Бусад өглөг	83,836,050.00	3,133,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	83,836,050.00	3,045,800.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	88,000.00
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**1,830,255,918.15**	**1,414,191,063.21**
51	Засгийн газрын хувь оролцоо	1,830,255,918.15	1,414,191,063.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,596,924,523.84	1,596,924,523.84
51101	Өмч: - төрийн	1,596,924,523.84	1,596,924,523.84
512	Хуримтлагдсан үр дүн	223,218,306.71	(192,846,548.23)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,607,037,611.44)	223,218,306.71
51220	Тайлант үеийн үр дүн	1,830,255,918.15	(416,064,854.94)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,113,087.60	10,113,087.60
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**1,914,091,968.15**	**1,426,501,619.57**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**2,490,544,734.56**	**2,158,876,500.00**
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,294,511,534.56	1,328,376,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,294,511,534.56	1,328,376,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	372,005,500.00	1,328,376,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	372,005,500.00	1,328,306,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	586,017,975.56	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	1,336,488,059.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,033,200.00	830,500,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	196,033,200.00	454,800,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,033,200.00	454,800,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	375,700,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	317,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	58,000,000.00
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**660,288,816.41**	**1,890,148,354.94**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	660,288,816.41	1,890,148,354.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575,433,116.73	1,874,119,086.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,705,863.39	609,036,906.90
210101	Үндсэн цалин	93,472,125.00	404,844,043.90
210102	Нэмэгдэл	33,053,620.93	65,947,879.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,936,748.00	95,312,900.00
210104	Урамшуулал	11,243,369.46	42,932,084.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,239,216.30	87,939,700.00
210201	Тэтгэврийн даатгал	12,743,318.34	64,846,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,623,949.49	5,773,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,299,159.51	4,618,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	324,789.98	1,154,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,247,998.98	11,546,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,040,000.00	2,523,100.00
210301	Гэрэл, цахилгаан	-	1,384,200.00
210302	Түлш, халаалт	-	574,400.00
210303	Цэвэр, бохир ус	-	564,500.00
210304	Байрны түрээс	1,040,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	11,905,419.63	33,649,796.58
210401	Бичиг хэрэг	4,007,890.00	11,544,550.00
210402	Тээвэр, шатахуун	1,461,700.00	5,586,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,779,189.63	12,888,126.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	656,640.00	3,630,520.00
2105	Норматив зардал	-	564,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	564,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	270,000.00	24,610,965.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,454,200.00
210604	Урсгал засвар	270,000.00	23,156,765.00
2107	Томилолт, зочны зардал	5,767,300.00	58,538,770.00
210702	Дотоод албан томилолт	5,767,300.00	58,538,770.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	213,353,094.00	783,141,158.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,073,094.00	731,311,110.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	174,048.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,280,000.00	51,634,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,152,223.41	274,114,689.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,015,000.00	141,100,855.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,137,223.41	133,013,834.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,855,699.68	16,029,267.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,979,964.34	16,029,267.95
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,979,964.34	16,029,267.95
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,875,735.34	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,875,735.34	-
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**1,830,255,918.15**	**268,728,145.06**
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	684,793,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	684,793,000.00
4	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)**	**-**	**(684,793,000.00)**
5	**НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)**	**1,830,255,918.15**	**(416,064,854.94)**

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**-**	**-**	**-**	**-**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,596,924,523.84	-	(1,607,037,611.44)	(10,113,087.60)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,596,924,523.84	-	(1,607,037,611.44)	(10,113,087.60)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	10,113,087.60	-	10,113,087.60
Тайлант үеийн үр дүн	-	-	1,830,255,918.15	1,830,255,918.15
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,596,924,523.84**	**10,113,087.60**	**223,218,306.71**	**1,830,255,918.15**
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,596,924,523.84	10,113,087.60	223,218,306.71	1,830,255,918.15
Тайлант үеийн үр дүн	-	-	(416,064,854.94)	(416,064,854.94)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,596,924,523.84**	**10,113,087.60**	**(192,846,548.23)**	**1,414,191,063.21**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**568,038,700.00**	**2,165,121,500.00**
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	372,005,500.00	1,334,621,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	372,005,500.00	1,334,621,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	372,005,500.00	1,334,621,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	372,005,500.00	1,334,386,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	235,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,033,200.00	830,500,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	196,033,200.00	454,800,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,033,200.00	454,800,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	375,700,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	317,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	58,000,000.00
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**517,461,500.00**	**2,104,226,200.00**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	517,461,500.00	2,104,226,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	432,601,803.32	1,865,598,928.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,705,863.39	605,830,443.00
210101	Үндсэн цалин	93,456,118.00	401,637,580.00
210102	Нэмэгдэл	33,069,627.93	65,947,879.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,936,748.00	95,312,900.00
210104	Урамшуулал	11,243,369.46	42,932,084.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,239,216.30	87,939,700.00
210201	Тэтгэврийн даатгал	12,743,318.34	64,846,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,623,949.49	5,773,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,299,159.51	4,618,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	324,789.98	1,154,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,247,998.98	11,546,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,040,000.00	2,523,100.00
210301	Гэрэл, цахилгаан	-	1,384,200.00
210302	Түлш, халаалт	-	574,400.00
210303	Цэвэр, бохир ус	-	564,500.00
210304	Байрны түрээс	1,040,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	13,721,869.63	36,508,546.58
210401	Бичиг хэрэг	4,847,640.00	12,847,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,905,000.00	6,650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,779,189.63	12,888,126.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,190,040.00	4,122,520.00
2105	Норматив зардал	-	564,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	564,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,924,000.00	32,392,165.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	904,000.00	8,805,400.00
210604	Урсгал засвар	3,020,000.00	23,586,765.00
2107	Томилолт, зочны зардал	5,767,300.00	58,538,770.00
210702	Дотоод албан томилолт	5,767,300.00	58,538,770.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	173,050,904.00	885,877,453.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	173,050,904.00	811,567,405.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	174,048.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	74,114,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,152,650.00	155,424,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,152,650.00	155,424,750.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,859,696.68	238,627,271.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,983,961.34	16,029,267.95
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,983,961.34	16,029,267.95
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,875,735.34	222,598,003.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,875,735.34	222,598,003.67
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)**	**50,577,200.00**	**60,895,300.00**
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	50,576,600.00	60,895,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,576,600.00	60,895,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,576,600.00	60,895,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,576,600.00	60,895,900.00
6	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)**	**(50,576,600.00)**	**(60,895,900.00)**
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	600.00	(600.00)
9	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**-**	**600.00**
10	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**600.00**	**-**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**1,789,186,500.00**	**1,566,824,096.33**	**222,362,403.67**	**87.6**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,789,186,500.00	1,566,824,096.33	222,362,403.67	87.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,752,519,500.00	1,550,794,828.38	201,724,671.62	88.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,830,500.00	605,830,443.00	57.00	100.0
210101	Үндсэн цалин	401,637,600.00	401,637,580.00	20.00	100.0
210102	Нэмэгдэл	64,183,000.00	65,947,879.00	(1,764,879.00)	102.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	95,312,900.00	95,312,900.00	-	100.0
210104	Урамшуулал	44,697,000.00	42,932,084.00	1,764,916.00	96.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,939,700.00	87,939,700.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	64,846,400.00	64,846,400.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,773,300.00	5,773,300.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,618,600.00	4,618,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,154,800.00	1,154,800.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,546,600.00	11,546,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,523,100.00	2,523,100.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,384,200.00	1,384,200.00	-	100.0
210302	Түлш, халаалт	574,400.00	574,400.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	564,500.00	564,500.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	38,739,100.00	36,508,546.58	2,230,553.42	94.2
210401	Бичиг хэрэг	13,048,000.00	12,847,900.00	200,100.00	98.5
210402	Тээвэр, шатахуун	6,717,100.00	6,650,000.00	67,100.00	99.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,019,000.00	12,888,126.58	1,130,873.42	91.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,955,000.00	4,122,520.00	832,480.00	83.2
2105	Норматив зардал	1,485,000.00	564,000.00	921,000.00	38.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,485,000.00	564,000.00	921,000.00	38.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	257,930,000.00	93,288,065.00	164,641,935.00	36.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	69,701,300.00	69,701,300.00	-	100.0
210604	Урсгал засвар	188,228,700.00	23,586,765.00	164,641,935.00	12.5
2107	Томилолт, зочны зардал	66,777,500.00	58,538,770.00	8,238,730.00	87.7
210702	Дотоод албан томилолт	66,777,500.00	58,538,770.00	8,238,730.00	87.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	535,304,400.00	510,177,453.80	25,126,946.20	95.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	439,438,700.00	435,867,405.80	3,571,294.20	99.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	919,500.00	174,048.00	745,452.00	18.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	38,500.00	22,000.00	16,500.00	57.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	94,787,700.00	74,114,000.00	20,673,700.00	78.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,000.00	-	120,000.00	00.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,990,200.00	155,424,750.00	565,450.00	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,990,200.00	155,424,750.00	565,450.00	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,667,000.00	16,029,267.95	20,637,732.05	43.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,667,000.00	16,029,267.95	20,637,732.05	43.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,427,000.00	16,029,267.95	20,397,732.05	44.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	-	240,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**1,789,186,500.00**	**1,789,421,500.00**	**(235,000.00)**	**87.6**
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	454,800,000.00	454,800,000.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	454,800,000.00	454,800,000.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,334,386,500.00	1,334,621,500.00	(235,000.00)	83.3
120004	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,334,386,500.00	1,334,386,500.00	-	83.3
1200044	Төсөвт байгууллагын өөрийн орлого туслах	-	235,000.00	(235,000.00)	-
4	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**-**	**600.00**	**(600.00)**	**-**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**-**	**-**	**-**	**-**
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	37	37	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**-**	**375,700,000.00**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	375,700,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	375,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	375,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	375,700,000.00
II	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**-**	**375,700,000.00**
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	375,700,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	317,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	58,000,000.00

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмчийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитор О.Наранбат нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/0096 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хянал

Жижиг, дунд үйлдвэрийн газар нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны салбарыг эрчимтэй хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, хөнгөлөлттэй зээл, татаас олгох, улмаар нийгэм, эдийн засагт жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын эзлэх байр суурийг бэхжүүлэх, тэдгээрийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлж, төрийн дэмжлэг үзүүлэх, тэдний эрх ашигт нийцсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Агентлаг байгуулах тухай” 49 дүгээр тогтоолын 1-т “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Жижиг, дунд үйлдвэрийн газар”-ыг байгуулсугай” гэж заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төсөв захирагчдын Шилэн дансны тухай хууль болон тушаал шийдвэрийн хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж, биелэлтийг хангаж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,921,802.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 28,827.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 487,590.35 мянган төгрөгөөр буюу 25.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.6	-	(0.6)
Авлага	4.0	289,031.5	289,027.5
Урьдчилгаа	-	7,200.0	7,200.0
Бараа материал	1,388,630.0	676,930.7	(711,699.3)
Үндсэн хөрөнгө	525,457.4	453,339.4	(72,117.9)
Нийт хөрөнгө	1,914,092.0	1,426,501.6	(487,590.3)
Өр төлбөр	83,836.1	12,310.6	(71,525.5)
Засгийн газрын хувь оролцоо	1,830,255.9	1,414,191.1	(416,064.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,914,092.0	1,426,501.6	(487,590.3)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 289,031.5 мянган төгрөг болж, 289,027.5 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага 222,598.0 мянга, АНУ болон Канад улсад зохион байгуулагдах “Монголд үйлдвэрлэв үзэсгэлэн”-ийн арга хэмжээ 2022 онд зохион байгуулагдахаар хойшлогдсоноос үүссэн танхимын түрээс, онгоцны тийзийн зардлын 50,459.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 5,970.2 мянган төгрөг бүртгэгдсэнээс шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал 7,200.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад ашиглагдаж буй төсвийн төлөвлөлтийн нэгдсэн программын 2022 оны лицензийн төлбөрийг “Дата ланд технологи” ХХК-нд урьдчилан шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 676,930.7 мянган төгрөг болж, 711,699.3 мянган төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Агентлаг байгуулах тухай” 49 дүгээр тогтоолын 4.3-т “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, хуримтлагдсан эх үүсвэр, өглөг, авлага зэргийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасныг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/273 дугаар тушаал, Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны А/52 дугаар тушаалаар эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байсан 409 ширхэг 684,793.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий бэлэн бүтээгдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд балансаас балансад шилжүүлэн бүртгэснээс голлон шалтгаалжээ.

Бараа материалын дансанд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой найдваргүй болсон зээлийн эргэн төлөлтөд хураан авсан, борлуулах зорилготой Сэлэнгэ аймгийн Мандал сумын 7 дугаар багт байрлах 292,875.0 мянган төгрөгийн өртөгтэй Хараа хотхоны нэгдүгээр байрны таван айлын орон сууц, Сонгинохайрхан дүүргийн 1, 20 дугаар хороонд байрлах 12,613 м.кв талбайтай 308,183.0 мянган төгрөгийн 2 газар бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 453,339.4 мянган төгрөг болж, 72,117.9 мянган төгрөгөөр буурсан нь ЖДҮГ-ын даргын 2021 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/21 дүгээр тушаалын дагуу урсгал төсвийн санхүүжилтээр 60,895.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан хөрөнгөөр нэмэгдэж, тайлант онд 133,013.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 12,310.6 мянган төгрөг болж, 71,525.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд бүтэц, орон тоо, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орж, байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалтай холбоотой бичиг хэрэг, ном хэвлэл, төсөв санхүүгийн программ, зээлийн сонгон шалгаруулалтын нэгдсэн программын лицензийн төлбөр, түрээсийн зардал зэрэг 16 байгууллагад 83,836.1 мянган төгрөгийн өглөгтэй байсныг тооцоо нийлсэн актыг үндэслэн төлж барагдуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд хувь хүний орлогын албан татварын өглөг 9,176.8 мянга, бичиг хэрэг, материалын өглөг 2,968.8 мянган төгрөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 416,064.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн бууралт болон эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 684,793.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй балансаас баланст шилжүүлснээс шалтгаалсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 331,668.2 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар буурч, нийт зардал өмнөх оноос 1,229,859.5 мянган төгрөгөөр буюу 86.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого болон нэмэлт санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй гарсан зардал данс байна.

Энэ нь өмнөх оноос үндсэн үйл ажиллагааны орлого 956,301.0 мянга, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 258,766.8 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 375,700.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 1,922,506.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд сүүлийн дөрвөн сарын санхүүгийн үйл ажиллагаанд тайлан бэлтгэж гаргасан, шинэ бүтэц зохион байгуулалттай холбоотой хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, хоршооллын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний санхүүжилтээс голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,591,425.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс агентлагийн бүтэц, орон тооны шинэчлэл, үйл ажиллагааны чиглэлтэй холбогдуулан Сангийн яамнаас 3,586,646.8 мянган төгрөгөөр буюу цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 842,561.4 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 107,593.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 137,442.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,240,805.5 мянган төгрөгөөр бууруулж, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/435 дугаар албан бичгээр тус байгууллагын 2021 оны төсвийг 2,004,778.8 мянган төгрөгөөр баталж хүргүүлсэн байна.

Дээрх батлагдсан төсвөөс 215,592.3 мянган төгрөгийн дутуу санхүүжилт олгож, мөн төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 222,598.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар тусгасан нь төсвийн төлөвлөлтийг бодитой боловсруулаагүй байгааг харуулж байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,789,186.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 454,800.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,334,386.5 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 454,800.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,334,622.1 мянган төгрөг, нийт 1,789,422.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,566,824.1 мянган төгрөгийг зарцуулж, 222,598.0 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,566,824.1 мянган төгрөг буюу 87.6 хувьтай байгаа нь урсгал засварын зардлыг 164,641.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 25,127.0 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 8,238.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг 222,362.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагааны зардлын арга хэмжээг 180,539.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг арга хэмжээг 20,397.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл */мянган төгрөг/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх ажлын байр олгох	1,789,186.5	1,566,824.1	222,362.4	87.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,328,496.0	1,147,956.3	180,539.7	86.4
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	22,415.7	20,991.7	1,424.0	93.6

1.3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	25,900.0	25,800.0	100.0	99.6
1.4	80218	Улс орноо гадаадад сурталчлах	102,950.0	100,966.6	1,983.4	98.1
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	31,427.0	11,029.3	20,397.7	35.1
1.6	82540	Монголд үйлдвэрлэв үзэсгэлэн	90,880.0	90,880.0	-	100.0
1.7	82611	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	187,117.8	169,200.2	17,917.6	90.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Хөрөнгө гаргах тухай” 344 дүгээр тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас хоршооллын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд 317,700.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас буюу ХХААХҮС-ын 2021 оны “Эрх шилжүүлэх тухай” А/53 дугаар, тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны “Санхүүжилт олгох тухай” А/101 дүгээр тушаалаар Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний 2.1-т заасан зорилтын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд эмх цэгцтэй нэг эх үүсвэрээр хүртээмжтэй түгээх ажлын 58,000.0 мянга нийт 375.700.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 7 арга хэмжээний хэрэгжилт 93.9 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 87.6 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Агентлаг байгуулах тухай” 49 дүгээр тогтоол, ХХААХҮС-ын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/273 дугаар тушаалаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн ажлын албыг татан буулгаж, агентлагийн албан хаагчдын чиг үүрэг, орон тоо, үйл ажиллагааны зардал, өглөг, авлага, цалингийн сан, эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг Жижиг, дунд үйлдвэрийн газарт шилжүүлэн бүртгэж, санхүүгийн тайланг тусдаа бэлтгэж тайлагнасан хэдий ч Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаатай холбоотой найдваргүй зээлийн эргэн төлөлтөд хураан авсан, худалдан борлуулах зорилготой үл хөдлөх хөрөнгө тус байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 123 мэдээлэл байршуулахаас 41 мэдээллийг хугацаа хоцроож байршуулж, 89,592.0 мянган төгрөгийн 6 зарлагын гүйлгээг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*", 6 дугаар зүйлийн 6.4.5 -д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "*төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргын 2021 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/21 дүгээр тушаалаар 7 бараа, ажил үйлчилгээний зардалд 385,000.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 165,540.0 мянган төгрөгийн 4 бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж, гэрээ дүгнэсэн акт үйлдэн хүлээлгэн өгч, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилт 57.1 хувийн үзүүлэлттэй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Жижиг, дунд үйлдвэрийн газар нь Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн “Агентлаг байгуулах тухай” 49 дүгээр тогтоолоор шинэ бүтэц, зохион байгуулалтад орсон тул 2020 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жижиг, дунд үйлдвэрийн газрын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 75.0 хувийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн орлогоос төсвийн хуваариар баталж, санхүүжилт олгож байгаа нь сангийн тухайн жилийн үйл ажиллагааны орлоготой уялдуулан санхүүжүүлэх, тодорхой хязгаар тогтоосон зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгагдаагүй нь анхаарал татахуйц байсан тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 386,212.5 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, 358,631.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 5,200.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 19,630.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 2,750.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 27,581.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 28,827.0 мянган төгрөгөөс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Кассын тайлангийн орлого, зарлагын гүйлгээг 101,567.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг 222,598.0 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн;
- Цалингийн зардлыг 7,466.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Тооцооны дансаар дамжуулалгүй 27,000.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн.

4.2 Төлбөрийн акт

Засгийн газрын 2021 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Хоршоологчдын 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд шилдэг хоршоод болон эссэ бичлэгийн шагнал, урамшуллын зардалд 52,000.0 мянган төгрөг олгосноос хувь хүний орлогын албан татварын 10 хувь болох 5,200.0 мянган төгрөгийг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах*", Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д "*суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг*", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-т ”*Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй 5,200.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 101/ШШ2020/03320, 2021 оны 101/ШШ2021/00655 дугаар шийдвэрээр нийт 12,210.6 мянган төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “*Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ*”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "*Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий хоёр ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон 12,210.6 мянган төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Бараа материалын дансанд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн найдваргүй зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 292,875.0 мянган төгрөгийн өртөгтэй 5 айлын орон сууц, 308,183.0 мянган төгрөгийн өртөгтэй нийт 12,613 м.кв талбайтай 2 газар бүртгэлтэй байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн

"*Агентлаг байгуулах тухай*" 49 дүгээр тогтоолын 4.3 "*Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, хуримтлагдсан эх үүсвэр, өглөг, авлага зэргийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах*", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлд "*Төрийн өмчийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх*", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн "*Ажлын хэсэг байгуулах тухай*" А/273 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансанд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн бүртгэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан тушаалтны гадаад албан томилолтын зардалд 7,419.7 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 55,321.1 мянган төгрөгийн 339 ширхэг хөрөнгөд дахин үнэлгээ хийгдээгүй, актлах арга хэмжээ авч ажиллаагүй нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд "*Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах*", 7 дугаар зүйлд "*Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:Үндсэн хөрөнгийн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, цаашид ашиглах боломжтой элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй болсон хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, ашиглах боломжгүй хөрөнгийг акталж данснаас хасах;

2. Үндсэн хөрsөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын шинжтэй 2,750.7 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас батлагдсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй бараа материалыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж, холбогдох журмын дагуу данс бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр, аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
						Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар													
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар АХГ-2022/352/НА-СТА-ТШЗ	Кассын тайлангийн орлого, зарлагын гүйлгээг 101,567.5 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан байна	Санхүүгийн тайланд залруулах	1	101,567.5	1	101,567.5						
2		Төсвийн гүйцэтгэлийн тайланг 222,598.0 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	222,598.0	1	222,598.0						
3		Цалингийн зардлыг 7,466.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	7,466.0	1	7,466.0						
4		Тооцооны дансаар дамжуулалгүй 27,000.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	27,000.0	1	27,000.0						
5		Засгийн газрын 2021 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Хоршоологчдын 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд шилдэг хоршоод болон эссэ бичлэгийн шагнал, урамшуллын зардалд 52,000.0 мянган төгрөг олгосноос хувь хүний орлогын албан татварын 10 хувь болох 5,200.0 мянган төгрөгийг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.	Төлбөрийн акт тогтоох	1	5,200.0			1	5,200.0				
6		Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 101/ШШ2020/03320, 2021 оны 101/ШШ2021/00655 дугаар шийдвэрээр нийт 12,210.6 мянган төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон байна	Албан шаардлага	1	12,210.6					1	12,210.6		

7		Бараа материалын дансанд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн найдваргүй зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 292,875.0 мянган төгрөгийн өртөгтэй 5 айлын орон сууц, 308,183.0 мянган төгрөгийн өртөгтэй нийт 12,613 м.кв талбайтай 2 газар бүртгэлтэй байна	Албан шаардлага	1	-					1	-		
8		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан тушаалтны гадаад албан томилолтын зардалд 7,419.7 мянган төгрөг зарцуулсан байна.	Албан шаардлага	1	7,419.7					1	7,419.7		
9		Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын шинжтэй 2,750.7 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө бүртгэлтэй байна.	Зөвлөмж	1	2,750.7							1	2,750.7
10		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 55,321.1 мянган төгрөгийн 339 ширхэг хөрөнгөд дахин үнэлгээ хийгдээгүй, актлах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	Зөвлөмж	1	-							1	-
ДҮН				10	386,212.5	4	358,631.5	1	5,200.0	3	19,630.3	2	2,750.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал													
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар АХГ-2022/352/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд 123 мэдээлэл байршуулахаас 82 мэдээллийг хугацаандаа, 41 мэдээллийг хугацаа хоцроож, 89,592.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг ил тод мэдээлж байршуулаагүй байна.	Албан шаардлага	1	-						-		
	ДҮН			1	-	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН				**11**	**386,212.5**	**4**	**358,631.5**	**1**	**5,200.0**	**3**	**19,630.3**	**2**	**2,750.7**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 16/А0160067 Улаанбаатар хот
АХГ-2022/352/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2021 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан "Хоршоологчдын 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх" үндэсний хөтөлбөрийн хүрээнд шилдэг хоршоод болон эссэ бичлэгийн шагнал, урамшууллын зардалд 52,000,000.00 төгрөг олгосноос хувь хүний орлогын албан татварын 10 хувь болох 5,200,000.00 төгрөгийг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19 "*суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг*", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1 "*Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна*" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй 5,200,000.00 /таван сая хоёр зуун мянган/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Audltin 2 Gazar-4.Docx

1001090031

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 55/А0160067 Улаанбаатар хот

АХГ-2022/352/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 123 мэдээлэл байршуулахаас 41 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 89,592,019.20 /наян есөн сая таван зуун ерэн хоёр мянга арван есөн/ төгрөгийн 6 зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.5 *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 *"төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-7.Docx

001081602

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 56/А0160069 Улаанбаатар хот
АХГ-2022/352/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн найдваргүй зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 292,875,000.00 /хоёр зуун ерэн хоёр сая найман зуун далан таван мянган/ төгрөгийн өртөгтэй 5 ширхэг орон сууц, 308,182,950.00 /гурван зуун найман сая нэг зуун наян хоёр мянга есөн зуун тавин/ төгрөгийн өртөгтэй нийт 12,613 м2 талбайтай 2 газар бүртгэлтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн "*Агентлаг байгуулах тухай*" 49 дүгээр тогтоолын 4.3 "*Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, хуримтлагдсан эх үүсвэр, өглөг, авлага зэргийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах*", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлд "*Төрийн өмчийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх*", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн "*Ажлын хэсэг байгуулах тухай*" А/273 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын дансанд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн бүртгэх талаар арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР — Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

001080100

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 57/А0160069
АХГ-2022/352/НА-СТА-ТШЗ
Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан тушаалтны гадаад албан томилолтын зардалд 7,419,698.00 /долоон сая дөрвөн зуун арван есөн мянга зургаан зуун ерөн найман/ төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР — Д.БОЛОР-ЭРДЭНЭ

9006109
9019120596

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 58/А0160069 Улаанбаатар хот
АХГ-2022/352/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 101/ШШ2020/03320, 2021 оны 101/ШШ2021/00655 дугаар шийдвэрээр нийт 12,210,652.95 төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "*Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ*" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Нэр бүхий хоёр ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон нийт 12,210,652.95 /арван хоёр сая хоёр зуун арван мянга зургаан зуун тавин хоёр ерэн таван/ төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Алтансүх, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
9019120596

ТЭМДЭГЛЭЛ